

АВТО ЗАМЫН АШИГЛАЛТЫН БЭЛЭН БАЙДЛЫН ТҮВШИНГЭЭР САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү журам нь авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлын түвшингийн үзүүлэлтийг тогтоож, гаргасан үзүүлэлтийг үндэслэн батлагдсан норм, нормативын дагуу Зам хариуцагч байгууллагын үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх арга хэмжээг зохицуулахад оршино.
- 1.2 Авто замын арчлалт, урсгал засварын ажлыг тухайн замын ашиглалтын бэлэн байдлын түвшинг үндэслэн норм, нормативээр санхүүжүүлнэ.
- 1.3 Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх норм, норматив гэж Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2016 оны 4-р сарын 26-ны өдрийн 152/101 тоот тушаалаар хамтран баталсан /Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын суурь норм ЗЗБД 84-021-2016/-г ойлгоно. Тус нормыг, Авто замын тухай хуульд нийцүүлэн мөрдөнө.
- 1.4 Зам, тээврийн сайдын 2016 оны 2-р сарын 18-ны 37 тоот тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын зохион байгуулалтын техникийн дүрэм ЗЗБНД 41-011-2016/-ийн Хавсралт 2 “Авто замын бэлэн байдлын түвшинг үнэлэх, эдгээр үзүүлэлтүүдийг үндэслэн санхүүжүүлэх аргачлал” нь Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшинг тодорхойлох, түүнийг санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг зааварчилсан техникийн баримт бичиг болно.

2. АВТО ЗАМЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ

- 2.1 Авто зам, замын байгууламжийн бэлэн байдал нь тухайн замын үндсэн хийц хэсгүүдэд хийсэн үзлэг, хэмжилтээр өгсөн үнэлгээний итгэлцүүрээр тогтоогдоно. Замын үндсэн хийц хэсгүүдэд үнэлгээ өгөхдөө, тодорхой урт бүхий замын хэсгүүдийн ашиглалтын байдлыг газар дээр нь шалгаж Хүснэгт №1-д өгсөн /2-оос 5 хүртэл/ баллаар дүгнэнэ.
- 2.2 Авто замын бэлэн байдлын үзлэгийг нийт замд хийх бөгөөд хэмжилт шалгалтыг тухайн чиглэлийн замын бэлэн байдлыг бодитойгоор тогтоож болохоор нийтлэг хийц бүхий хэсгүүдийг сонгож авч хийнэ.
- 2.3 Авто зам, замын байгууламжид үүссэн дараах тохиолдлуудыг ашиглалтын бэлэн байдлын үнэлгээнд хамааруулан тооцохгүй . Үүнд:
 - 2.3.1 Байгалийн гэнэтийн аюул, гамшигт үзэгдлийн улмаас эвдэрсэн авто зам, замын байгууламжийг засварлах ажил бүрэн дуусаагүй тохиолдолд:
 - 2.3.2 Сайжруулсан шороон замын шуудууны сэргээлт сайн хийгдсэн боловч хавар газар шорооны гээлтийн үед зам дээр бамбалзуур үүссэн бол:
 - 2.3.3 Зам, замын байгууламжийн зарим хийц хэсэг нь гадны хүчний нөлөөгөөр эвдэрсэн ба уг хэсэгт хийгдэх сэргээн босголтын ажлын хугацаа дуусаагүй үед:
 - 2.3.4 Шалгалтын үед замын аль нэг хэсэгт их засвар, шинэчлэлт хийгдэж байгаа бол, тэгэхдээ тухайн хэсэгт түр зам гарган өгч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй өнгөрөөх боломжоор хангасан тохиолдолд. Хэрэв ийм нөхцөлийг хангахгүйгээр зам хааж хөдөлгөөн саатуулсан байвал уг замын зохих хэсэгт "МУУ" үнэлгээ өгнө.
 - 2.3.5 Үзлэг шалгалтын хамрах хугацаанд тухайн авто замын бэлэн байдал алдагдсанаас шалтгаалан зам тээврийн осол гарсан нь холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн сарын үнэлгээг "МУУ" гэж үзнэ.

**АВТО ЗАМЫН БЭЛЭН БАЙДЛЫН ТҮВШИНГ ТОГТООХ ХИЙЦ ХЭСГИЙН ҮНЭЛГЭЭНД
БАРИМТЛАХ ЭВДРЭЛИЙН ШИНЖ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

№	Замын хийцүүд	Бэлэн байдлын үнэлгээнд харгалзан үзэх эвдрэлүүд			
		Муу /2 балл/	Дунд /3 балл/	Сайн /4 балл/	Онц /5 балл/
1	<u>Замын хучилт /P1/</u> 1.1 Хучилттай зам – цементбетон – асфальтбетон – хөнгөвчилсөн хатуу хучилт	-Хучилтанд 200 м2-аас том талбайтай гүн хонхор цоорхой гарч /3см-ээс илүү гүнтэй/ эвдэрснийг засаагүй. -Замын зорчих хэсэгт тойрч гарахаас аргагүй том цоорхой цөмөрхий эвдрэл үүссэнийг засаагүй. -Хучилтан дээр ус тогтсон, хог шороонд бохирдсон, тусгайлан тэмдэг тавьж анхааруулаагүй тохиолдолд осол аварт оруулж болохоор янз бүрийн зүйл хог зам дээр хаягдсан байх -Шуурч хунгарласан цас арилгадаагүй, хальтиргаа арилгах бодис цацагдаагүй, хамгаалах материал бэлтгэгдээгүй, мөсдөлт, хатуурсан цасан гөлүүр үүсч хальтиргаа гарсан. $K_{авц}=0.0-0.15$	-Хучилт эвдрэлд орсон, хучлагын чулуулаг хэсэг ховхорч 3 см хүртэл хэмжээний гүнтэй 200 см2-аас их нүх хонхор үүссэнийг засаагүй. -Цементбетон хучилтад өнгөний гадаргууд халцралт эвдрэл үүссэнийг засаагүй. -Хучлагын дээд үед гарсан гулсалт тасралт үүссэнийг засаагүй. -Хавтан хашлагыг ирмэг эмтэрч эвдэрсэн хэвээрээ бол. -Ан цав, заадсууд мастикаар дүүргэгдээгүй. -Нүхний засварыг муу хийснээс олон товоон үүссэн. -Хучлага дээр хог цэвэрлэгдээгүй байх. -Хучлага дээрх хатуурсан цасыг цэвэрлээгүй байх.	-Хөлдөлт, усанд идэгдэж өнгөний хууралт холцролт, хэсэг хэсэг хотойлт олон товоон үүссэн. -Битум ихэдсэн хэсэгт элс, дайрга цацагдаагүй байх. -Ан цавын зарим хэсэгт битумын мастик хийгдээгүй байх -Хучилтан дээрх цасыг арилгасан боловч гадагруугийн 10% ов тов нимгэн цастай тэр нь хальтиргаанд нөлөөлөхөөргүй байх, хуурай материал цацаж хальтиргаанаас хамгалсан байх. -Хурд огцом хасах шаардлагагүй тохиолдолд.	-Эвдрэлгүй -Хучилтан дээр цасан бүрхүүлгүй. -Хучилтын хальтиргааг арилгасан, бодис цацсан. -Хучилтын хөвөөнд суулт гараагүй, хөндлөнгийн хэвгий өөрчлөгдөөгүй -Хучилтанд долгион үүсээгүй. -Асфальтбетон хучилтын ан засвар битумээр, цементбетон замын заадас мастикаар дүүргэгдсэн байх. -Тооцоот хурдаар хэвийн явах нөхцөл хангагдсан
	1.2 Хучилтгүй зам – хайрга болон дайрган – сайжруулсан хөрсөн	-Үргэлжилсэн дэргигнүүр үүссэн /гүдгэр, хонхор 3см-ээс их/ -Хучилтанд нүх хонхор, цоорхой үүссэн. Ус тогтсон, тусгайлан тэмдэг тавьж анхааруулаагүй тохиолдолд осол гарч болзошгүй. -Хатуурсан цасан болон мөсөн бүрхүүл үүсч хальтиргаа гарсан байх. $K_{авц}=0.0-0.15$	-Хучилт өнгөц эвдэрч, дугуйны мөр гарсан, дэргигнүүр / гүдгэр, хонхор нь 1-3см/ үүссэн, замын зорчих хэсгийн дайрга, хайрга нь барьцалдаагүй сул үсчсэн, хогтой, зам дээрх дагтаршаагүй сийрэг цас 20 см-ээс дээш гараагүй байх. $K_{авц}=0.15-0.25$	-Замын гадаргуугийн хөндлөн огтлолд бага зэрэг өөрчлөлт орсон. -Хучилтын цасыг цэвэрлэсэн боловч гадаргуугийн 10%-д ов тов цастай, гэвч хурд сааруулах шаардлагагүй. -Хэсэгчилсэн дэргигнүүртэй /гүдгэр, хонхор 1см хүртэл, уртын 20%-аас ихгүй/.	-Эвдрэлгүй -Хучилтын цас мөсийг бүрэн цэвэрлэсэн байх. -Замыг тоосгүйжүүлэх арга хэмжээ тогтмол авсан бол.
2.	<u>Шороон далан ба ус зайлуулах байгууламж /P2/</u>	-Замын ирмэг, налуу угаагдсан, усны шуудуу элс шороонд дарагдаж ус урсахгүй болсон, ирмэг дээр бут, сөөг мод ургасан, усны лоток эвдэрсэн. -Хучлагын ирмэгийн түвшин хөвөөнийхөөс 40мм-ээс илүү их зөрүүтэй болсон. -Замын хөвөөний цас арилаагүй хунгарт дарагдсан.	Хажуу налуу, хажуугийн шуудуу ба бэлтгэл газрын хог ургамал өвс бут сөөг зайлуулаагүй, хөвөөний хөндлөн огтлол өөрчлөлттэй, зорчих хэсгийн ирмэгээс доош суусан /40см-ээс бага/ -Далангийн хажуу налуу зарим газар урссан, хөвөөний өргөн нарийссан. -Хөвөөн дээр дугуйн мөр, нүх хонхор цоорхой үүссэн. -Замын хөвөөний талаас илүү нь цастай байх.	-Хөвөөний хэвгий бага зэргийн /±20% хүртэл/ өөрчлөлттэй.	-Хөндлөнгийн болон хажуугийн налууд хэв гажилт үүсээгүй байх.
3.	<u>Гүүр, хиймэл байгууламж /P3/</u> 3.1 Гүүр	-Зорчих хэсгийн заадас, дамжих хавтан эвдэрсэнийг засаагүй. -Олон цэгт төмөрбетон бүтээцийн бетон ховхорч, арматур ил гарсаныг	-Зарим эд ангиудын тогтвортой байдал нь алдагдахааргүй гэмтлүүд гарсаныг засаагүй. -Бетон болон төмөрбетон хийцүүдэд	-Гүүрийн хэвийн ажиллагаанд саад болохооргүй жижиг эвдрэл гарсан /дам нурууны гадна халтарсан, өнгөн эвдрэл/	-Эвдрэлгүй -Гүүрийн зорчих хэсэг, явган замыг цас, мөс хогноос цэвэрлэсэн

		<p>засаагүй.</p> <p>-Ган хийцийн гол цэгүүд эвдрэлтэй, зэвэрсэн</p> <p>-Хийцүүдийн бэхлэгээний эрэг боолт алга болсон</p> <p>-Модон хавчаас, хавчуурганд хагаралт, өмхөрөлт гарсан.</p> <p>-Явган замын хийцүүд эвдэрсэн.</p> <p>-Конус налуугийн бэхлэгээ эвдэрсэн.</p>	<p>эвдрэл, ан цавтай.</p> <p>-Арматурын зарим цухуйлтууд гарсныг засаагүй.</p> <p>-3-8см тэгш биш гадаргуутай</p> <p>-Бүх төрлийн жижиг эвдрэл 3% хүртэл гарсан.</p> <p>-Ган хийцүүд эвдрэлтэй, тулах хэсгийн бетон эвдэрсэн.</p> <p>Хийцүүдийн бэхлэгээний эрэг боолт суларсан</p> <p>-Модонд бага зэргийн ялзрал үүссэн.</p>	<p>-Нарийн хялгасан жижиг цууралт үүссэн.</p> <p>-Зарим хэсгийн хадаас боолт суларсан.</p> <p>-Модон гүүрийн зангилааны хэсэгт бага зэрэг эвдрэл гарсан.</p>	<p>-Өнгө будагны засал хийгдсэн</p> <p>-Заадас хагаралгүй, жигд ажиллаж байгаа.</p> <p>-Өмхрөлт /модны/ явагдаагүй.</p>
	3.2 Хоолой	<p>-Хоолойнд суулт үүсч, цагирагнууд зөрсөн.</p> <p>-Хоолойны орчмын далан сэтэрсэн.</p> <p>-Дохионы шонгууд унасан, алга болсон.</p> <p>-Хоолойны толгой далавч эвдэрсэн.</p> <p>-Хоолой болон орох гарах амсарууд хог, шороогоор дүүрсэн.</p> <p>-Хоолойн орох гарах амсарыг өвөл тагладаггүй, хавар онгойлгоогүй бол</p>	<p>-Хоолойн толгойн далавчинд ан цав, хугаралт хэмхрэлт үүссэн.</p> <p>-Хоолойн зарим цагирагуудад яльгүй суулт үүссэн.</p> <p>-Хоолойн дотор зарим газарт хог, шороо хуралдсан.</p> <p>-Хоолой цасаар дүүрсэн.</p> <p>-Хоолойн дээрх дохионы шон хазайсан бол</p>	<p>-Амсар толгойны эд ангиудад өнгөлгөө хийгээгүй.</p> <p>-Шохой, будаг хийгээгүй.</p> <p>-Хоолойн нүх, амсар цасанд дарагдаагүй.</p>	<p>-Эвдрэлгүй.</p> <p>-Орох гарах амсарыг өвлийн улиралд тагласан.</p> <p>-Дохионы шонгууд бүрэн, хазайгаагүй.</p>
4.	<u>Замын тэмдэгжилт тоноглол</u> <u>/P4/</u>	<p>-Зайлшгүй шаардлагатай газруудаар байх ёстой хаалт, хамгаалалт, дохионы шон тэмдэг, заалтууд тавигдаагүй буюу шаардлага хангахгүй болсон.</p> <p>-Дохионы шон, тэмдэг, самбарууд хазайсан, зарим нь алга болсон, хугарсан</p>	<p>-Тэмдэг байрлуулах журам заавар зөрчиж тэмдэг, заалт тавьсан.</p> <p>-Чиглүүлэгч хэрэгсэл, замын тэмдэг, хаалт хашлага, босоо ба хэвтээ тэмдэглэгээ цасанд дарагдсан буюу бохирдсоноос танигдахгүй болсон, эвдэрсэн.</p> <p>-Журамлагдаадгүй гарц оролттой, тэмдэглэгээг чанаргүй муухай хийсэн.</p> <p>-Явган хүний замын хучилт ихээхэн эвдэрсэн.</p>	<p>-Замын тэмдэг дохионы шон, мэдээллийн хэрэгсэлүүд бага зэргийн бохирдолтой, гэмтэлтэй</p> <p>-Тэмдэг тоноглолын 10%-ийг засах, сэргээх шаардлагатай.</p>	<p>-Эвдрэлгүй.</p> <p>-Замын тэмдэг, тэмдэглэгээ, хашлага, хашилт, явган хүний зам бүрэн бүтэн цэвэр үзэмжтэй.</p>
5.	<u>Тохижилт үйлчилгээний байгууламж /P5/</u>	<p>-Тохижилт үйлчилгээний газруудын байршил хууль зөрчсөн, замын ашиглалтын байдалд сөрөг нөлөө үзүүлдэг.</p> <p>-Зогсоол, талбай хог шороо, цас мөсөнд дарагдсан.</p> <p>-Замын дагуух овоо, сүсэг бишрэлийн бусад цэгүүд амрах талбай хогонд дарагдсан байх.</p> <p>-Үйлчилгээний газрууд руу очих зам нь гол замын хажуугийн шуудууг таглаж, ус урсах боломжгүй болгосон.</p> <p>-Зогсоолын талбайд 00-ын цэг, хог хаях цэг байхгүй, байгаа нь дүүрэн хогтой бол</p>	<p>-Тохижилт үйлчилгээний цэгийн байршил хууль дүрмэнд нийцсэн боловч хог ихтэй, замбараагүй.</p> <p>-Зогсоол талбай хогонд дарагдсан.</p> <p>-Овоозэргийн орчинг тохижуулаагүй.</p> <p>-Үйлчилгээний газрууд руу очих гарцад хоолой тавьсан боловч тэр ньжижигдэж, хажуугийн шуудууны усыг гаргаж чаддаггүй.</p> <p>- Зогсоолын талбайд 00-ын цэг, хог хаях цэг эвдэрсэн, эсвэл хогтой бол</p>	<p>-Тохижилт үйлчилгээний байгууламжууд ялимгүй бохирдолтой, үзэмж тааруухан.</p> <p>-Үйлчилгээний газрууд руу орох гарцууд дээр ус өнгөрүүлэх зохих голчтой хоолой тавиулсан.</p> <p>- Зогсоолын талбайд 00-ын цэг, хог хаях цэг байгаа боловч бага зэргийн хогтой бол</p>	<p>-Тохижилт үйлчилгээний бүх цэгүүд өнгө үзэмж сайтай, хууль дүрмийн дагуу байршсан.</p> <p>-Үйлчилгээний газрууд руу орох гарц үлгэр жишээ хийгдсэн.</p> <p>- Зогсоолын талбайд 00-ын цэг, хог хаях цэгтэй, хогоо байнга цэвэрлэж ачдаг бол</p> <p>- Шаардлага хангасан цэвэр усны нөөцийн савтай бол</p>

3. АВТО ЗАМЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ

- 3.1 Авто замын бэлэн байдалд хяналт шалгалт хийж ашиглалтын түвшинг үнэлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 3.1.1 Авто замын засвар арчлалтын ажлыг сар бүр уг замыг хариуцсан Захиалагчийн төлөөлөгч /томилогдсон тохиолдолд Зөвлөх/ болон, Зам хариуцагчийн ерөнхий инженер, анхан шатны нэгжийн дарга, мастерыг оролцуулсан ажлын хэсэг дараа сарын 5-ны дотор багтааж шалгана. Шаардлагатай гэж үзвэл ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Зам хариуцагчийн захирал, орон нутгийн замын цагдаа, хэрэглэгчид /Замын зөвлөл/-ийн төлөөлөгчдийг оролцуулж болно. Хяналт шалгалтын үзлэгийг Захиалагч, Зөвлөх, байцаагч нар хэдийд ч, замын хэмжээ харгалзахгүй хийж болно. Ажлын хэсэг нь авто замын бэлэн байдлын үнэлгээг хийхдээ тухайн замыг газар дээр нь очиж үзлэг шалгалт хийж тус журмын 1, 2 дугаар хүснэгтэд заасны дагуу үнэлгээ өгч дүгнэнэ.
- 3.1.2 Олон улс, улсын чанартай авто замын бэлэн байдлын үнэлгээ тогтоох шалгалтыг улирал тутам, дараа улирлын эхний сарын 10-ны дотор багтааж явуулна. Энэ шалгалтыг Захиалагч байгууллагын удирдлагын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг хийнэ. Ажлын хэсгийн дарга нь Захиалагчийн төлөөлөгч /хэлтсийн дарга, мэргэжилтнүүд/ байх ба бүрэлдэхүүнд нь Зөвлөх, Мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл болон Зам хариуцагчийн төлөөлөгч, уг замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан замын цагдаа, зам хэрэглэгчид /Замын зөвлөл/-ийн төлөөлөгчийг оролцуулна.
- 3.1.3 Ажлын хэсэг тухайн замын шалгалт хийгдэх хэсгийн уртыг хучилтын төрлөөс хамааруулан сонгож авна. Гэхдээ сонгосон замын урт 20 км-ээс ихгүй байна. Хэрэв тухайн зам нэг төрлийн хучилттай бол сонгосон сайн муу хэсгүүдийн тоо аль болох ойролцоо буюу ижил байхаар авна.
- 3.1.4 Авто замын техник ашиглалтын байдал, замын хийцүүдийн чанар, ашиглалтын түвшинд хийсэн үзлэг шалгалтын дүгнэлтээр хүснэгт №2-ыг бөглөж ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Мөн тухайн авто зам, замын байгууламжийг хариуцсан засвар арчлалтын анхан шатны нэгжийн дарга эсвэл ерөнхий инженерийг заавал байлцуулж өгсөн үнэлгээг танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 3.1.5 Ажлын хэсэг шалгалтын явцад Зам хариуцагчийн үйл ажиллагаанд гарч байгаа алдаа, доголдол түүнийг засах талаар заавар зөвлөмж, шаардлага, үүрэг даалгаврыг зам хариуцагчид өгч тэмдэглэл хөтөлнө.
- 3.1.6 Захиалагч, Зам хариуцагч байгууллагын хамтарсан шийдвэрээр авто зам, замын байгууламжийн бэлэн байдлын түвшинг, холбогдох мэргэжлийн байгууллага, хүмүүсээр тогтоолгож болно.
- 3.1.7 Замын бэлэн байдлын үнэлгээ тогтоох шалгалт хийх үед замын засвар арчлалтын байгууллагууд дараах бичиг баримтыг ажлын хэсэгт заавал үзүүлнэ. Үүнд:
- Зам, замын байгууламжид хийсэн өдөр тутмын үзлэгийн журналууд болон авто замын паспорт, гүүрийн карт
 - Замын тэмдэгжилтийн нэгдсэн схем жагсаалт
 - Засвар арчлалтын ажилд хийсэн хяналт шалгалтын дүнгийн хүснэгт
 - Өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт
 - Өнгөрсөн улиралд замын бэлэн байдлын түвшинг тогтоосон хүснэгт №2-оор гаргасан хэмжилт, шалгалтын дүнгийн хүснэгт

А.....ДУГААРТАЙ.....ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН БЭЛЭН
БАЙДЛЫГ ТОГТООХ ХҮСНЭГТ

.....он.....сар.....өдөр

Д/д	Замын хийцүүд, ач холбогдлын итгэлцүүр	Өгөх үнэлгээ /баллаар/	Шалгалтад хамрагдсан		Зохих үнэлгээ		Хийц тус бүрийн чанарын үнэлгээний дүн /P/
			Хэсгүүд /км/	Бүгд /км/	Үнэлгээ	Чанарын үнэлгээ / P/	
0	1	2	3	4	5	6	7
1.	Хучилт, хөвөө $m_1=0.55$	2-5					
2	Шороон далан, шуудуу $m_2=0.10$	2-5					
3	Гүүр, хоолой $m_3=0.20$	2-5					
4	Тохижилт, үйчилгээний цогцолбор $m_4=0.05$	2-5					
5	Тэмдэгжилт, замын тоноглол $m_5=0.10$	2-5					

Ажлын хэсгийн дарга:..... гарын үсэг:/...../

Гишүүд:.....

Ажлын хэсгийн үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн:.....

Гүүрийн үзлэгийн картыг хүснэгт №3-аар тус тус гаргаж хавсаргана.

ГҮҮРИЙН ҮЗЛЭГИЙН КАРТ

Гүүрийн дугаар №	Гүүрийн нэр			Замын чиглэл			Голын нэр:		Хариуцагч байгууллага:		
Байршил:				Гүүрийн барилгын ажил гүйцэтгэгч компани :			Ашиглалтад орсон огноо:		Гүүр бариулсан инженер		
Засвар хийгдсэн эсэх:	Хучилт:	Хавтан дам нуруу:	Ус залах далан, бэхэлгээ	Хөл тулгуур:	Заадас:	Будаг:	Тулах хэсэг:	Ус тусгаарлалт:	Хайс:	Дугуй цохигч:	
Гүүрийн хийц:	Эвдрэлийн байдал:				Хувь:	Гүүрийн хийц:	Эвдрэлийн байдал:			Хувь:	
Зорчих хэсэг	Хучилт:	Сайн, муу, дэржигнүүр, донсолгоо, хагарал, эвдрэл гарсан				Доод бүтэц	Захын тулгуур: №	эвдрэл хагарал, арматур ил гарсан, суулт үүссэн			
	Дугуй цохигч:	Сайн, муу, хагарал, арматур ил гарсан					Завсарын тулгуур: №	эвдрэл хагарал, арматур ил гарсан, суулт үүссэн			
	Хайс:	Сайн, муу, эвдрэл хагарал, арматур ил гарсан					Ар хана:	эвдрэл хагарал, арматур ил гарсан,			
	Дам нуруу:	Сайн, муу, эвдрэл, хагарал, арматур ил гарсан					Далавч:	эвдрэл хагарал, арматур ил гарсан,			
	Тулах хэсэг:	Сайн, муу, эвдрэл, хагарал, арматур ил гарсан.					Ригель:	эвдрэл хагарал, арматур ил гарсан,			
							Ус залах далан, бэхэлгээ	эвдрэл хагарал,			
	Тэмдэг, то ноглол:	Бий:	Үгүй:			Санал: Цаашид авах арга хэмжээ:				Ашиглалтын байдлын үнэлгээ:	
		Муу:	Сайн:								
	Будаг:	Сайн:			Муу:						
Заадас:	Сайн:	Муу:	Эвдэрсэн:	Хагарсан:							
Ус гаргах цорго:	Сайн:	муу:	солих:	засварлах:							

Гүүрийн ерөнхий байдлын зураг хавсаргана. /4-н талаас нь харуулсан/

4. ЗАМЫН АШИГЛАЛТЫН БЭЛЭН БАЙДЛЫН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ

- 4.1 Үзлэг хийгдэх замын сонгосон хэсэг тутамд хийц тус бүр эвдрэлийн шинж байдлаар онц /5/, сайн /4/, дунд /3/, муу /2/ гэсэн баллаар үнэлгээ өгнө
- 4.2 Авто замын бэлэн байдлыг замын хийцүүдийн ашиглалтын байдал, түүнд хийгдсэн ажлын чанарын үнэлгээ, ач холбогдлын итгэлцүүрээр тодорхойлно.
- 4.3 Авто замын сонгосон хэсэг тутамд хийц тус бүрийн эвдрэлийн шинж байдлыг бүртгэж үнэлгээнд баримтлах эвдрэлийн шинж байдлыг үнэлэх хүснэгт №2-оор үнэлж, боловсруулалт хийж шалгалтад хамрагдсан хэсгийн уртад нь засвар арчлалтын ажлын чанарын үнэлгээг хийц тус бүрд өгнө.
- 4.4 Бэлэн байдлын түвшинг тогтоох шалгалтад хамрагдсан замын сонгосон хэсгүүдийн хийцэд өгсөн үнэлгээ илэрсэн эвдрэлээс болж янз бүр байвал хамгийн бага үнэлгээтэй хэсгийг авна.
- 4.5 Хийц тус бүрийн бэлэн байдлын үнэлгээг замын шалгалтад сонгосон хэсгийн уртад нь дараах томъёогоор олно. Өөрөөр хэлбэл аль нэг хийцэд өгсөн үнэлгээ тус бүрийг тухайн сонгосон хэсгийн уртаар үржүүлэн нийлбэрийг нь сонгосон хэсгүүдийн нийт уртад хувааж P_n -ийг тодорхойлно.

$$P = \frac{m_1 I_1 + \dots + m_n I_n}{L_i} \quad /1/$$

m_1, \dots, m_n - сонгосон хэсэг тус бүрд байгаа нэг төрлийн хийцэд өгсөн чанарын үнэлгээ

I_1, \dots, I_n - сонгосон хэсэг тус бүрийн урт

L_i -сонгосон хэсгүүдийн уртын нийлбэр

- 4.6 Замын хэсэг тус бүрийн үнэлгээ „ P_n ”, болон хүснэгт №1 дахь ач холбогдлын итгэлцүүр „ m_n ”,-ийг ашиглан нийт замын бэлэн байдлын түвшин „ S ”,-ийг дараах томъёогоор олно.

$$S = \frac{m_1 P_1 + m_2 P_2 + m_3 P_3 + m_4 P_4 + m_5 P_5}{N} \quad /2/$$

m -замын хийцүүдийн ач холбогдлын итгэлцүүр

P - замын хийц тус бүрийн үйлчилгээний түвшингийн үзүүлэлт

P_1 - замын хучилтын

P_2 - шороон далангийн

P_3 -гүүр, хиймэл байгууламжийн

P_4 -замын тэмдэгжилт, тоноглолын

P_5 -замын тохижилт, үйлчилгээний цогцолборын

N - замын хийцүүдийн тоо

- 4.7 Тодорхой нэг зам хариуцсан анхан шатны нэгжийн хувьд замын бэлэн байдлын түвшинг 2-р томъёогоор тодорхойлно. Харин хэд хэдэн зам хариуцсан анхан шатны нэгжийн хувьд энэ үзүүлэлтийг дараах томъёогоор олно.

$$S = \frac{S_1 L_1 + \dots + S_i L_i}{L_1 + L_2 + \dots + L_i} \quad /3/$$

S_i -аль нэг замын бэлэн байдлын түвшин

L_i - аль нэг замын урт

5. САНХҮҮЖИЛТ

- 5.1 Замын бэлэн байдлын үнэлгээний тоон утгад харгалзах Хүснэгт №4-д байгаа хувь хэмжээгээр тухайн зам хариуцагч байгууллагын гүйцэтгэсэн засвар арчлалтын ажлын санхүүжих нормативт зардлыг тогтооно.
- 5.2 Санхүүжилтийн үндсэн баримт нь зам хариуцагч байгууллагын гаргаж, ажлын хэсгийн хянасан гүйцэтгэл болон Хавсралт-1-д үзүүлсэн акт болно.

Хүснэгт №4

**АВТО ЗАМЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ҮНДЭСЛЭН
УРСГАЛ ЗАСВАР АРЧЛАЛТЫН АЖЛЫН НОРМАТИВТ
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ**

Д/д	Замын бэлэн байдлын түвшин	Нормативт зардлыг санхүүжүүлэх хувь	Тайлбар
А	1	2	3
1.	1.0-0.85	100	
2.	0.84-0.75	80	
3.	0.74-0.65	70	
4.	0.64-0.55	60	
5.	0.54-0.40	50	

Тайлбар: Замын засвар арчлалтын ажлын чанарын бүх үзүүлэлтүүд /хийц хэсэг бүрээр/ онц дүнтэй байвал чанарын түвшин 1.0-тэй тэнцүү байх бөгөөд зөвхөн энэ тохиолдолд санхүүжилтийн нормативт зардлын 10 хүртэл хувиар шагналын хувь ногдуулж болно.

**АВТО ЗАМЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ҮНДЭСЛЭН УРСГАЛ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН АЖЛЫН НОРМАТИВТ
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ АКТ**

.....оныр сарын.....ны өдөр

.....

/газрын нэр/

.....
/Зам хариуцагч байгууллагын нэр/

.....
/шалгалт хийгдсэн хугацаа/

Дараах бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг

Дарга

/нэр, албан тушаал/

Гишүүд.....

.....нарыг байлцуулан

/байгууллагын нэр, албан тушаал, нэр/

.....
/замын нэр, урт км-ээр/

замуудадонысарыннд засвар арчлалтын ажлын чанарт үнэлгээ өгч, замын бэлэн байдлын түвшин тогтоох шалгалт хийв.

Шалгалт хийгдсэн замд зам хариуцагчийн буруугаас гарсан зам тээврийн осол

.....
/хаана, ямар шалтгаанаас ямар осол гарсныг тодорхой бичнэ./

газар дээр нь шалгаж, эвдрэлийг бүртгэж, хийц тус бүрээр үнэлгээ өгснөөр

.....
/замуудын нэр/

замын бэлэн байдлын түвшинггэж тогтоов.

/үнэлгээг бичгээр/

Замын байгууллагын хариуцаж байгаа дээрх замуудын урсгал засвар арчлалтын нормативт зардлыг замын бэлэн байдлын түвшингийн дээрх үнэлгээг үндэслэн%-иар олгох нь зүйтэй гэж үзэв.

Ажлын хэсгийн дарга: /гарын үсэг/

/байгууллагын нэр, албан тушаал, нэр/

Гишүүд.....

/байгууллагын нэр, албан тушаал, нэр/

Ажлын хэсгийн үнэлгээтэй танилцаж

зөвшөөрсөн

/байгууллагын нэр, албан тушаал, нэр/